

Санхүүгийн тайлагналын чанар ба хяналтын функцийн харилцан хамаарал

Relationship Between the Quality of Financial Reporting and Control Functions

А. Одгэрэл¹, Б. Мөнхбат², Г. Энхцэцэг³

Хураангуй

Бид Beest нарын хөгжүүлсэн аргазүйг ашиглан Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй TOP20 компанийн 2018-2020 оны санхүүгийн тайлан, жилийн тайлангийн мэдээллийг ашиглан санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих оролдлого хийсэн. Санхүүгийн тайлагналын чанар нь хөндлөнгийн аудит, дотоод аудит болон аудитын хорооноос шууд хамааралтай гэж таамаглан дээрх аргазүйгээр үнэлэхэд хөндлөнгийн аудитын чанараас хамгийн өндөр хамааралтай буюу хамаарлын коэффициент 0.462 гарч батлагдсан. Тиймээс бид санхүүгийн тайлангийн чанарыг нэмэгдүүлэхэд хөндлөнгийн аудиторын чанар чухал ач холбогдолтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Түлхүүр үгс: санхүүгийн мэдээллийн чанар, аудитын хороо, дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын чанар, дотоод аудитын чанар

Abstract

The research objectives are to examine the relationship between the control function and quality of financial reporting. The quality of financial reporting is measured using 21-item questionnaire that is created by Beest et al.. In this study, data is collected the 2018-2020 financial statements and annual reports of the TOP20 companies listed on the Mongolian Stock Exchange. According to the survey results, the quality of the financial reporting index is measured as 40 percent. Furthermore, we assumed that the quality of the financial reporting depends directly on external audit, internal audit function and audit committee. As survey results, the quality of the financial statements is 99%, and the confidence level is the most dependent on the quality of the external audit, with a correlation coefficient of 0.462. Therefore, we conclude that the quality of the external auditor is important in improving the quality of the financial statements.

Keywords: quality of financial reporting, audit committee, internal audit function, external audit quality

¹ СЭЗИС-ийн Олон улсын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэргэшсэн сургууль
E-mail: odgerel.a@ufe.edu.mn

² СЭЗИС-ийн Олон улсын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэргэшсэн сургууль
E-mail: munkhbat.bo@ufe.edu.mn

³ СЭЗИС-ийн Олон улсын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэргэшсэн сургууль
E-mail: enkhsetseg.g@ufe.edu.mn

Удиртгал

АНУ-ын хөрөнгө оруулагч Warren Buffet нэгэн цагт “Нягтлан бодох бүртгэл бол бизнесийн хэл юм” гэж хэлсэн байдаг. Хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч болон удирдлага болон бусад оролцогч талууд энэхүү нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн чанарыг чухалчилжүздэг. Харамсалтай нь, өнөөгийн корпорацийн орчинд дэлхийн олон компаниудын санхүүгийн тайлагналын чанарт асуудал тулгарсаар байгааг Enron, WorldCom болон Lehman brothers, Toshiba зэрэг томоохон корпорациудын санхүүгийн луйврын хэргүүд харуулж байна.

Монгол Улсын хувьд 2008 онд хийсэн Нягтлан бодох бүртгэл, аудитын СХДЖХ-д Дэлхийн банкны зүгээс хөндлөнгийн үнэлгээ хийсэн ба уг үнэлгээгээр ААН-үүдийн санхүүгийн тайлагналын чанар, хугацааны хувьд ноцтой алдаатай, “Аудитлагдсан санхүүгийн тайланг үнэн зөв, шударгаар гаргасан гэдэгт зээлдүүлэгч, хөрөнгө оруулагчид эргэлздэг” гэж гаргасан.

2016 онд МҮЦАЭХ болон Спүүнмедиа ХХК-ийн хамтран хийсэн судалгаагаар судалгаанд оролцогчдын 43 хувь нь огт санхүүгийн тайланг уншиж танилцаагүй, мөн 32 хувь нь хувьцаат компанийн санхүүгийн тайлангийн мэдээлэлд дунд зэрэг итгэдэг бол 25 хувь нь итгэдэггүй гэсэн үр дүн гарсан. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчдын 79 хувь хувьцаат компанийн санхүүгийн мэдээлэл, үйл ажиллагааны болон цаг үеийн мэдээллийг цаг алдалгүй авах сонирхолтой байдаг хэдий ч мэдээллийн ил тод нээлттэй байдал хангалтгүй байна гэж 73 хувь нь үзсэн байна⁴.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих судалгаанууд нэлээд хийгдсэн байна. Тухайлбал, Гантулга (2018) СТОУС-ын чанарыг хэмжих эмпирик загвар ашиглан МХБ-д бүртгэлтэй компаниудын 2012-2014 оны санхүүгийн тайлангийн чанарыг 33.8 хувь, 2015-2016 оны хувьд уг үзүүлэлт 32.5 хувь гэж үнэлсэн байна. Харин Ninjin (2019) СТОУС-ын нийцлийн аргазүйд тулгуурлан тооцсон МХБ-д бүртгэлтэй компаниудын санхүүгийн тайлангийн толилгуулгын индекс 24.2 хувь, Botosan-ний аргазүйд ашиглан тооцсон сайн дурын толилуулгын индекс 40.1 хувь гэж тооцоолсон ба судлаач сайн дурын толилуулгын түвшин толилуулгын түвшингээс харьцангуй өндөр хэдий ч компаниудын толилуулга хангалтгүй түвшинд хэвээр байна гэж дүгнэсэн.

Санхүүгийн тайлангийн мэдээлэлд итгэх итгэл буурах шалтгааныг санхүүгийн тайлагналын системтэй холбоотой үзэж байсан бол, үүнээс хойш томоохон корпорациудын луйвар, залилангаас үүдэлтэй санхүүгийн хямралыг судалсан судалгаанууд хийгдсэн ба ялангуяа санхүүгийн луйвар, луйврыг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хөндлөнгийн аудит болон дотоод хяналтын тогтолцооны сул, зохисгүй байдлыг авч үзсэн байна (Sami, 2009).

МУ-н Компанийн засаглалын кодекс 2014-т Санхүүгийн тайлагналын үндсэн зорилго нь компанийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх явдал бөгөөд СТОУС-г мөрдөж, зохих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь орчин үеийн санхүүгийн тайлагналын системийг

⁴ Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал болон цаашдын хөгжлийн бодлогын талаарх санал асуулгын судалгааны тайлан-2016

төлөвшүүлэх боломжийг бүрдүүлэх юм гэж заасан.

Санхүүгийн тайлангийн чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх онолын судалгааг хийж, чанарыг хэмжих судалгааны аргазүйг боловсруулан, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын жишээн дээр санхүүгийн тайлагналын чанар болон хяналтын функцуудын хооронд ямар хамаарал байгааг судлан, санал зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Санхүүгийн тайлагналын чанарын үзэл баримтлал

Санхүүгийн тайлагналын гол зорилго нь мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой тайлагнагч ААН-ийн санхүүгийн мэдээллээр хангах явдал юм (IASB, 2008). Санхүүгийн тайлан нь тайлагнагч ААН-ийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайлангуудаас бүрддэг. Эдгээр тайлангийн найдвартай байдал, мэдээлэл хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд хөндлөнгийн аудиторуд уг тайлангуудыг хянаж баталгаажуулж байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд гарч буй дэлхийн томоохон корпорациудын санхүүгийн луйвар, дуулиант хэргүүд нь бизнесийн орчинд аудитлагдсан санхүүгийн тайлагналын чанарт ноцтой эргэлзээ төрүүлсээр байна. Тиймээс ч санхүүгийн тайлагналын чанарыг судлах оролдлогууд сүүлийн жилүүдэд дэлхийн өнцөг булан бүрт ихээхэн хийгдэж байна (Mbobo, 2016). Санхүүгийн тайлагналын чанар, түүнийг хэмжих талаар 2009 оноос хойш маш олон судлаачид судалсан байдаг. Тэдгээр судлаачдын ихэнх нь санхүүгийн

тайлагналын чанарыг НББОУСХ-ны үзэл баримтлалын хүрээнд чанарын элементүүдийг тодорхойлсон байна.

НББОУСХ-ноос гаргасан үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар нь уг мэдээллийн зорилго болон чанарын элементүүдээр тодорхойлогдоно (IASB, 2008). Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарын элементүүдийг хангаснаар уг мэдээллийн шийдвэр гаргалтад ашиглагдахуйц байдал сайжирдаг (Beest, Braam, & Boelens, 2009).

Санхүүгийн тайлагналын чанарын хэмжигдэхүүн

Санхүүгийн тайлангийн чанарыг нэмэгдүүлэхийн тулд тайланд тусгагдах мэдээллийг үнэн зөв, зохистой илэрхийлэх ёстой. Тиймээс санхүүгийн тайлангийн мэдээлэл нь зэрэгцүүлэгдэхүйц, найдвартай, цагхугацаандаа, ойлгомжтой байснаар тухайн мэдээллийн үр ашигтай байдал, чанар нэмэгдэнэ (IASB, 2008). СТОУС-ын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайлагналын чанарын хэмжигдэхүүнийг суурь элемент ба өргөжүүлсэн элемент гэж хоёр ангилдаг. Үүнд:

- Хамааралтай байдал (Relevance)

Хамааралтай байдал гэдэг нь ашиглагдахуйц болон материаллаг байдал гэсэн ойлголттой нягт холбоотой. Хамааралтай байдал нь мэдээлэл хэрэглэгчдийн шийдвэр гаргахад мэдээллийн ашиглагдах чадавхийг илэрхийлдэг. Бодит үнэ цэнийн хэмжил нь хамааралтай байдлыг илтгэх хамгийн чухал үзүүлэлтийн нэг бөгөөд тайлагнагч ААН-үүд хэмжилтийн суурь болгон бодит үнэ цэнийг ашиглах нь санхүүгийн тайлангийн мэдээллийн хамааралтай байдлыг илтгэх чухал үзүүлэлт юм (Beest, Braam, & Boelens, 2009).

- Найдвартай байдал (Reliability)
Энэ нь санхүүгийн тайлангийн чанарын нэг чухал элемент бөгөөд санхүүгийн тайлан дахь мэдээлэл нь шийдвэр гаргалтад ашиглагдахуйц байхын тулд найдвартай байх ёстой. Мэдээллийн найдвартай байдал нь хэрэглэгчид материаллаг алдаанаас ангид, бодит мэдээлэл авах боломжийг олгодог. Мэдээллийн найдвартай байдлыг төвийг сахисан, үнэн зөв толилуулгатай болон бодитой мэдээлэлд үндэслэн шинжилдэг (Cheung, Evans, & Wright, 2010).
- Зэрэгцүүлэгдэх байдал (Comparability)
Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь хэрэглэгчдэд зүйлүүд хоорондын ижил төстэй ба ялгаатай байдлыг тодорхойлж, ойлгож мэдэх боломжийг олгодог чанарын элемент юм (IASB, 2008). Зэрэгцүүлэгдэх байдал нь ААН-ийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, санхүүгийн байдлыг цаг хугацааны хувьд болон бусад ААН-үүдтэй харьцуулах боломжийг олгодог бөгөөд ингэснээр мэдээллийн чанарыг нэмэгдүүлдэг.
- Үнэн зөв толилуулга (Faithful presentation)
Үнэн зөв толилуулга нь санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн эдийн засгийн бодит нөхцөл байдалтай холбоотой чанарын үзүүлэлт юм. Үүний дагуу санхүүгийн тайлан дахь мэдээлэл нь иж бүрэн, төв голч, алдаагүй байх хэрэгтэй (IASB, 2008).
- Ойлгомжтой байдал (Understandability)
Ойлгомжтой байдал бол санхүүгийн тайлангийн мэдээллийн зайлшгүй чухал чанаруудын нэг бөгөөд энэ нь мэдээллийг ойлгомжтой ба товч тодорхой ангилж, тайлбарлаж, толи-

луулснаар мэдээллийн ойлгомжтой байдал сайжирдаг. Мэдээлэл ойлгомжтой байх нь үр дүнтэй харилцаа юм. Тиймээс хэрэглэгчдийн мэдээллийн талаарх ойлголт илүү сайн, илүү их чанартай байх болно (Cheung, Evans, & Wright, 2010).

- Цаг хугацаандаа байх (Timeliness)
Цаг хугацаандаа байх гэдэг нь мэдээллийг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд багтаан шийдвэр гаргагчдад хүргэхийг хэлнэ (IASB, 2008). Чанарын энэхүү үзүүлэлт нь нөлөө бүхий мэдээллээ хожимдож мэдэхээс өмнө шийдвэр гаргагчдад мэдээлэл нь ил тод, нээлттэй байх ёстойг харуулдаг бөгөөд мэдээлэл хуучрах тусмаа ач холбогдол нь буурч байдаг.

Санхүүгийн тайлагналын чанарыг хэмжих аргазүй

Санхүүгийн тайлагналын чанарыг үнэлж, хэмжих өмнөх судалгаануудад судлаачид санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг хэмжих маш олон аргачлал, загварыг ашигласан байдаг бөгөөд тэдгээр аргачлалыг ерөнхийд нь Аккруэл загвар, НББ-ийн консерватизм болон Ашгийн зохицуулалтын (Хэвийн бус аккруэл) загвар гэж ангилсан (Herath & Albarqi, 2017).

Харин судлаач Beest & Braam (2009), Herath & Alberqi (2017) нар санхүүгийн тайлагналын чанарыг үнэлж, хэмжих аргазүйг Аккруэл загвар, Үнэ цэнийн хамаарлын загвар, Санхүүгийн тайлан дахь тусгай элементийн загвар болон Чанарын элемент (шинж)-ийн загвар гэж ангилсан байна. Тэдний ангиллаар санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг хэмжих аргазүйг харьцуулж авч үзье (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг хэмжих арга зүй

Харьцуулалт	Аккруэл загвар	Үнэ цэнийн хамааралтай байдал	СТ дахь тусгай элементийн арга	Чанарын элементийн загвар
Аргазүй	Ашгийн удирдлагын түвшинг ашгийн чанарыг хэмжих үзүүлэлт болгон авдаг.	СТ-ийн мэдээллийн хамааралтай болон найдвартай байдлыг хэмжихийн тулд ашиг болон хувьцааны өгөөж хоорондын хамаарлыг шалгадаг. НББ-ийн мэдээлэл нь хувьцааны үнэд нөлөөлдөг учраас эдгээр үзүүлэлтүүд нь хоорондоо хүчтэй хамааралтай гэж үздэг.	Жилийн тайланд толилуулсан тодорхой нэг мэдээлэл нь хэрэглэгчдийн шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлөхийг шалгадаг.	СТ-ийн мэдээллийн шийдвэр гаргалтад ашиглагдах байдлын түвшинг мэдээллийн чанарын элементүүдээр үнэлж, шалгадаг.
Давуу тал	Гол давуу тал нь компанийн жилийн тайлангийн мэдээлэл дээр үндэслэн тооцож болдог тул мэдээлэл цуглуулахад харьцангуй хялбар байдаг.	Хэмжихэд харьцангуй хялбар, орлогын эдийн засгийн үнэ цэнийн талаарх ойлголтыг илэрхийлдэг.	СТ-ийн чанарт төвлөрдөг бөгөөд чанарыг хэмжих шууд арга юм.	СТ-ийн чанарт төвлөрдөг бөгөөд чанарыг хэмжих шууд арга юм.
Сул тал	Энэ аргын гол сул тал нь дискрешн болон дискрешн бус аккруэлийг ялгахад хүндрэлтэй байдаг. Мөн СТ-ийн чанарт бус ашгийн чанарт төвлөрч ашгийн чанарыг хэмжих шууд бус арга юм. Тиймээс энэ аргаар үнэлсэн СТ-ийн мэдээллийн чанарын талаарх дүгнэлт нь СТ-ийн мэдээллийн чанар, шийдвэр гаргалтад нөлөөлөх байдлын талаарх шууд болон иж бүрэн нотолгоо болж чаддаггүй.	СТ-ийн чанарт бус ашгийн чанарт төвлөрдөг, ашгийн чанарыг хэмжих шууд бус арга юм. Хамааралтай болон найдвартай байдлын хоорондын хамаарлыг илэрхийлдэггүй.	Зөвхөн сонгож авсан тодорхой элементүүдэд төвлөрдөг учраас санхүүгийн тайлангийн чанарыг иж бүрэн илэрхийлж чаддаггүй.	Хэмжихэд хүндрэлтэй.
Гол хэмжүүр	Ашгийн удирдлагын түвшинг хэмжихдээ дискрешн аккруэлийг (ашиг сонирхлын аккруэл) ашигладаг.	Хувьцааны үнэ болон НББ-ийн ашгийг ашигладаг.	Бодит үнэ цэнийн мэдээллийн чанар буюу үр ашигт нөлөөлөх байдал Материаллаг буруу тайлагналын магадлал	НББОУС-ын хорооны СТ-ийн чанарын элементүүдээр хэмждэг
Гол төлөөлөгч, зохиогчид	Healy (1985); DeAngelo (1986); Jones (1991); M.Dechow & G.Sloan (1995)	Nelson (1996); Choi, Collins, & Johnson (1997); Nichols & Wahlen (2004)	Hirst, Hopkins, & Wahlen (2004); Beneish, Charles, & Nichols (2013)	Schipper & Vincent (2003); Van der Meulen (2007); Barth (2007); Beest, Braam, & Boelens (2009)

Санхүүгийн тайлагнал дахь засаглалын хяналтын функүүдийн үүрэг

1992 онд Cadbury Committee-с “Компанийн засаглал гэдэг бол компанийг удирдан, чиглүүлэх, хянах тогтолцоо юм” гэж тодорхойлсон. Харин ОУСК-ийн хувьд “Компанийн засаглал нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, жижиг хувьцаа эзэмшигч, ТУЗ, удирдлага болон бусад оролцогч талуудын харилцаа юм” гэж тодорхойлсон. Тиймээс сайн засаглалын үндсэн зарчим нь компанийн үйл ажиллагаа оролцогч талуудад ил тод, нээлттэй хариуцлагатай, шударга, хяналттай байхыг шаарддаг.

МУ-ын Компанийн засаглалын кодекс 2014-т Санхүүгийн тайлагналын үндсэн зорилго нь компанийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх явдал бөгөөд санхүүгийн тайлагналын найдвартай системийг бий болгохын тулд СТОУС-ыг дагаж мөрдөх дүрэм журам, бодлого боловсруулж мөрдөх, зохих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, улмаар компанийн мэдээллийн ил тод, найдвартай байдлыг хангах ёстой гэж заасан байдаг.

- Дотоод аудитын функц: Судлаач Rezaee (2008), мөн Riley (2010) нар дотоод аудитын нэгжийн үүрэг, функц компанийн засаглалын өнөөгийн практикт маш чухал үүрэг оролцоотой бөгөөд ялангуяа дотоод аудит нь санхүүгийн тайлагналын чанарыг хангахад чиглэдэг байна гэж үзсэн (Anastasia, 2016). Parwit, Smith, & Wood (2009), Greco (2012) нарын хийсэн судалгаагаар сайн дотоод аудитын нэгжтэй компанийн хувьд аккрэул үнэ цэнийг бууруулах, ашгийг өсгөх зэрэг санхүүгийн луйвар, ашгийн зохицуулалтыг урамшуулдаггүй

болохыг илрүүлсэн (Anastasia, 2016). Эндээс дотоод аудитын нэгжтэй байх нь санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй.

- Хөндлөнгийн аудитын чанар: Хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын хувьд санхүүгийн тайлан үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн байх ёстой бөгөөд үүнийг хөндлөнгийн аудиторроор баталгаажуулах шаардлагатай. Тиймээс аудит гэдэг бол санхүүгийн тайлангийн найдвартай байдал, ашиглагдахуйц байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус баталгаажуулалт юм (Herath, 2017). Titman & Trueman (1986) нар хөндлөнгийн аудитын чанар өндөр байх нь санхүүгийн тайлангийн мэдээллийн найдвартай байдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдад компанийн үнэ цэнийг илүү нарийн, бодитой таамаглах боломжийг олгоно гэж үзсэн (Herath & Albarqi, 2017). Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн аудитын чанар нь компанийн толилуулсан санхүүгийн тайлангийн чанарын нэг хэсэг юм (Clinch, 2010). Аудитын чанар нь пүүсийн хэмжээ, нэр хүндтэй, мэргэшсэн байдалтай эерэг хамааралтай байх нь түгээмэл байдаг (Bing, 2014).

Аудитын чанар гэдэг ойлголтыг анх DeAngelo (1981) “аудитын пүүсийн хэмжээ, туршлагатай холбоотой” гэж үзсэн. Улмаар онолын болон эмпирик судалгаануудад “аудитын чанар нь пүүсийн хэмжээтэй нягт хамааралтай” болохыг баталсан (Bing, 2014). Leung нар (2005) хөндлөнгийн аудитор нь Их-4 байх нь санхүүгийн мэдээллийн чанар, найдвартай байдлын талаар зохих дохиог өгдөг гэдгийг илрүүлсэн (Anastasia, 2016).

- Аудитын хороо: Аливаа байгууллагын хувьд хараат бус хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, цалин урамшууллыг тогтоох, гүйцэтгэлийг аудитын хороо үнэлэх үүрэгтэй. Мөн аудитын хороо нь санхүүгийн тайлагналын бодлого, зарчим, дотоод хяналтын зохих тогтолцоо бий болгох, хяналт тавих зөвлөх үүрэгтэй (DeZoor, 1997). Тиймээс аудитын хороо нь санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм. Аудитын хороо нь хараат бус, өндөр чадамжтай, мэргэжлийн байх тусам алдаа, луйврыг илрүүлэх, сэргийлэх боломж нэмэгдэх, улмаар санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэх боломжтой юм. Тиймээс аудитын хороо нь санхүүгийн тайлагналын чанарт чухал нөлөө үзүүлнэ (Herath & Albarqi, 2017).

Судалгааны аргазүй

Энэхүү судалгаанд Санхүүгийн тайлагналын чанарыг СТОУС-ын үзэл баримтлалын чанарын мөн чанарыг илтгэх үндсэн болон өргөтгөсөн үзүүлэлтээр Beest нарын 2009 онд боловсруулсан аргазүйг ашиглав. Ингэхдээ санхүүгийн тайлангийн хамааралтай байдлыг 4 асуултаар, үнэн зөв байдлыг 5 асуултаар, ойлгомжтой байдлыг 4 асуултаар

зэрэгцүүлэгдэх байдлыг 5 асуултаар, цаг хугацаандаа байхыг 1 асуултаар, нийт 19 асуултаар үнэлсэн ба үнэлгээг өгөхдөө 1-5 оноогоор үнэлсэн. Санхүүгийн тайлагналын чанарт нөлөөлөх хяналтын функцыг өмнөх судалгааны үр дүнгүүдэд үндэслэн хөндлөнгийн аудитын чанар, дотоод аудитын нэгжтэй эсэх, аудитын хорооны мэргэшсэн байдал гэсэн зүйлээр тодорхойлж, хэрвээ байгаа бол 1 оноо, байхгүй бол 0 оноогоор үнэлсэн. Өмнөх судлаачдын онол болон эмпирик судалгаанд үндэслэн санхүүгийн тайлагналын чанарт компанийн хяналтын функцууд нөлөөлөх судалгааны загварыг боловсруулсан.

Дараах судалгааны таамаглалыг дэвшүүллээ.

H1. Дотоод аудитын нэгж нь санхүүгийн тайлагналын чанарт эерэг нөлөө үзүүлнэ.

H2. Хөндлөнгийн аудитын чанар санхүүгийн тайлагналын чанарт эерэг нөлөө үзүүлнэ.

H3. Аудитын хорооны мэргэшсэн байдал нь санхүүгийн тайлагналын чанарт эерэг нөлөө үзүүлнэ.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 174 компаниас 2021 оны TOP20 индексийн багцыг бүрдүүлж байгаа 20 компанийг сонгон авч судалгааг хийсэн ба судалгааны

Зураг 1. Судалгааны загвар



Хүснэгт 2. Түүвэр, салбараар

№	Үйл ажиллагааны чиглэл	Компанийн тоо	Эзлэх хувь	Үнэлэгдсэн		
				2018	2019	2020
1	Хүнсний үйлдвэрлэл	4	20	3	4	2
2	Тээвэр	1	5	1	1	1
3	Уул уурхай	2	10	2	2	1
4	Хөнгөн үйлдвэрлэл	2	10	2	1	1
5	Санхүү	8	40	8	8	7
6	Хөдөө аж ахуй	1	5	1	1	1
7	Худалдаа	2	10	2	2	2
	Нийт дүн	20	100	19	19	15

түүврийг салбараар Хүснэгт 2-т харуулав. Судалгааны түүвэрт хамрагдсан 20 компанийн 2018 оноос 2020 оны хооронд дахь гурван жилийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга, үйл ажиллагааны жилийн тайлан болон цахим хуудас дээрх нээлттэй мэдээллийг ашиглан өгөгдөл цуглуулсан.

Судалгааны үр дүн

Судалгааны асуулгын найдвартай байдлыг Cronbach-н Alpha коэффициентээр үнэлэхэд 0.807 буюу 80.7 хувь гэсэн үр дүн гарсан нь судалгааны үр дүн итгэж болохуйц найдвартай, судалгааны шаардлагыг хангасан байна.

Судалгаагаар санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих нийт 19 асуулт тус бүрээр дундаж үзүүлэлтүүдийг тооцож, үр дүнг гаргаж Хүснэгт 3-т харуулав. Тус хүснэгтээс харахад үйл ажиллагааны тайланд ашигласан мэргэжлийн үг хэллэг ойлгомжтой байдал хамгийн өндөр (81%) дундаж үзүүлэлттэй байхад үйл ажиллагааны тайланд таамаглал болон тооцоололтой холбоотой мэдээллийг толилуулдаг байдал хамгийн бага (26%) дундаж үзүүлэлттэй гарсан байна.

Бид дээрх 19 асуултаа санхүүгийн тайлангийн чанарын 5 хүчин зүйлээ

илэрхийлж чадаж байгаа эсэхийг шалгахын тулд фактор шинжилгээ хийж, үр дүнг Хүснэгт 4-т харуулав. Судалгааны нийт 19 асуултаас “хамааралтай байдал” гэсэн хүчин зүйлийг 4 асуулт, “үнэн зөв толилуулга” хүчин зүйлийг 5 асуулт, “ойлгомжтой байх” хүчин зүйлийг 4 асуулт, “зэрэгцүүлэгдэхүйц байх” хүчин зүйлийг 5 асуултаас 2 асуулт шаардлага хангаагүйн улмаас хасагдаж 3 асуултаар, цаг хугацаандаа байх гэсэн хүчин зүйлийг 1 асуултаар илэрхийлж санхүүгийн тайлангийн чанарын 5 хүчин зүйлийг 17 асуултаар бүрдүүллээ.

Фактор шинжилгээний үр дүнд тулгуурлан санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих таван хүчин зүйл тус бүрээр хэмжсэн чанарын индекс болон нийт чанарын жинлэгдээгүй индексийг Хүснэгт 5-д харуулав. Санхүүгийн тайлангийн чанарын индексийг тооцохдоо өмнөх судалгаануудад ашиглагдсан хоёр боломжит арга бол жинлэсэн ба жинлээгүй индекс тооцох хандлага юм (Bandara, 2020). Бид судалгаандаа санхүүгийн тайлангийн чанарын индекс тооцох жинлээгүй индексийн аргыг ашигласан ба шинжилгээний үр дүнгээс харахад санхүүгийн тайлангийн чанар дунджаар 40 хувиар үнэлэгдсэн. Харин чанарын хүчин зүйл тус бүрээр авч үзвэл цаг хугацаандаа байх байдал 65 хувь буюу хамгийн өндөр,

Хүснэгт 3. Санхүүгийн тайлангийн чанарын хэмжих асуулгын дундаж утга, стандарт хазайлт

	Дундаж	Ст. хазайлт
Жилийн тайландаа ирээдүйг таамагласан мэдээлэл (forward looking statement) толилуулдаг эсэх	35%	24%
Жилийн тайландаа бизнесийн эрсдэл болон боломжийн талаарх мэдээллийг толилуулдаг эсэх	35%	19%
Компани түүхэн өртгөөс илүү бодит үнэ цэнийг ашигладаг уу?	52%	29%
Зах зээлийн үйл явдлууд болон мэдэгдэхүйц үйл ажиллагаанууд компанид хэрхэн нөлөөлсөн талаарх мэдээллийг толилуулдаг эсэх	51%	20%
Үйл ажиллагааны тайлан дээр таамаглал болон тооцоололтой холбоотой мэдээллийг толилуулдаг уу?	26%	17%
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар жилийн тайландаа тодорхой тайлбарладаг эсэх	29%	24%
Компани жилийн тайландаа эерэг болон сөрөг үйл явдлуудыг хэр зэрэг тусгадаг вэ?	45%	9%
Жилийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн төрөл нь ямар байсан бэ?	78%	8%
Компанийн засаглалын талаар мэдээллийг дэлгэрэнгүй харуулдаг эсэх	44%	27%
Жилийн тайлангийн бүтэц хэр сайн бэ?	60%	33%
Санхүүгийн тайлангийн тодруулга нь хангалттай дэлгэрэнгүй байдаг уу?	43%	27%
Жилийн тайландаа хүснэгт болон график мэдээллийг хэр зэрэг харуулдаг вэ?	67%	29%
Үйл ажиллагааны тайланд ашигласан хэл болон мэргэжлийн үг хэллэг нь ойлгомжтой байдаг уу?	81%	23%
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн үндэслэлээ санхүүгийн тайлангийн тодруулгад тайлбарласан эсэх	62%	40%
НББ-ийн тооцоолол, удирдлагын үнэлэмжийн талаар санхүүгийн тайлангийн тодруулгад тайлбарласан эсэх	30%	25%
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн хэрэгжилтийн нөлөөг өмнөх үеийн санхүүгийн үзүүлэлтэд залруулдаг уу?	70%	39%
Жилийн тайланд толилуулсан мэдээллийг бусад байгууллагын мэдээлэлтэй зэрэгцүүлэх боломж хэр байдаг вэ?	68%	18%
Жилийн тайланд санхүүгийн шинжилгээ хийдэг эсэх	33%	21%
Жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтээ ил тод, хугацаандаа толилуулдаг эсэх	74%	22%

үнэн зөв толилуулга нь хамгийн бага буюу 32 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дээрх чанарын индексийг судалгаанд хамрагдсан компани тус бүрээр хэмжсэн ба үр дүнг Хавсралт 1-с харна уу.

Хүснэгт 6-д компанийн хяналтын функцууд болон аудитын хорооны мэргэшсэн байдал, хөндлөнгийн аудитын чанар, дотоод аудитын нэгжийн дундаж утга, стандарт хазайлтыг харуулав.

Судалгаанд Spearman-ний корреляцийн шинжилгээг ашигласан бөгөөд шинжилгээгээр санхүүгийн тайлангийн

чанар нь дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын чанар болон аудитын хорооны мэргэшсэн байдлын хооронд эерэг хамаарал байна. Шинжилгээний үр дүнгээс харахад санхүүгийн тайлангийн нийт чанар нь хөндлөнгийн аудитын чанараас хамгийн өндөр буюу 0.462 корреляцтай ба эдгээр хүчин зүйлс хоорондоо эерэг хамааралтай байгааг харуулж байна.

Хүснэгт 7-д харуулсан корреляцийн шинжилгээний үр дүнд санхүүгийн тайлагналын чанар нь 99 хувийн итгэх магадлалын түвшинд хөндлөнгийн аудитын

Хүснэгт 4. Фактор шинжилгээний үр дүн

	Хамааралтай	Үнэн зөв	Ойлгомжтой	Зэрэгцүүлэг-дэхүйц	Цаг хугацаандаа
Жилийн тайландаа ирээдүйг таамагласан мэдээлэл (forward looking statement) толилуулдаг эсэх	0.795				
Жилийн тайландаа бизнесийн эрсдэл болон боломжийн талаарх мэдээллийг толилуулдаг эсэх	0.763				
Компани түүхэн өртгөөс илүү бодит үнэ цэнийг ашигладаг уу?	0.493				
Зах зээлийн үйл явдлууд болон мэдэгдэхүйц үйл ажиллагаанууд компанид хэрхэн нөлөөлсөн талаарх мэдээллийг	0.676				
Үйл ажиллагааны тайлан дээр таамаглал болон тооцоололтой холбоотой мэдээллийг толилуулдаг уу?		0.822			
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар жилийн тайландаа тодорхой тайлбарладаг эсэх		0.832			
Компани жилийн тайландаа эерэг болон сөрөг үйл явдлуудыг хэр зэрэг тусгадаг вэ?		0.837			
Жилийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн төрөл нь ямар байсан бэ?		0.593			
Компанийн засаглалын талаар мэдээллийг дэлгэрэнгүй харуулдаг эсэх		0.676			
Жилийн тайлангийн бүтэц хэр сайн бэ?			0.815		
Санхүүгийн тайлангийн тодруулга нь хангалттай дэлгэрэнгүй байдаг уу?			0.902		
Жилийн тайландаа хүснэгт болон график мэдээллийг хэр зэрэг харуулдаг вэ?			0.592		
Үйл ажиллагааны тайланд ашигласан хэл болон мэргэжлийн үг хэллэг нь ойлгомжтой байдаг уу?			0.860		
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн үндэслэлээ санхүүгийн тайлангийн тодруулгад тайлбарласан эсэх				-0.568	
НББ-ийн тооцоолол, удирдлагын үнэлэмжийн талаар санхүүгийн тайлангийн тодруулгад тайлбарласан эсэх				0.980	
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн хэрэгжилтийн нөлөөг өмнөх үеийн санхүүгийн үзүүлэлтэд залруулдаг уу?				-0.888	
Жилийн тайланд толилуулсан мэдээллийг бусад байгууллагын мэдээлэлтэй зэрэгцүүлэх боломж хэр байдаг вэ?				0.783	
Жилийн тайланд санхүүгийн шинжилгээ хийдэг эсэх				0.583	
Жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтээ ил тод, хугацаандаа толилуулдаг эсэх					0.650

Хүснэгт 5. Санхүүгийн тайлангийн чанарын индекс

Чанарын хүчин зүйл	Дундаж	Медиан	Ст.хаз.
Хамааралтай байдал	33%	30%	1.07
Үнэн зөв толилуулга	32%	36%	0.87
Ойлгомжтой байдал	53%	55%	1.41
Зэрэгцүүлэгдэх байдал	38%	40%	0.99
Цаг хугацаандаа байх	65%	60%	1.59
СТ-гийн нийт чанарын индекс (жинлээгүй утга)	40%	43%	0.19

Хүснэгт 6. Үл хамааран хувьсагчийн дундаж утга, стандарт хазайлт

Хяналтын функц (Үл хамааран хувьсагчид)	Дундаж	Ст.хаз.
Дотоод аудитын нэгжтэй эсэх	0.70	0.46
Хөндлөнгийн аудитын чанар	0.25	0.44
Аудитын хорооны мэргэшсэн байдал	0.50	0.50

Хүснэгт 7. Хувьсагчдын корреляцийн шинжилгээ

	Дотоод аудитын нэгжтэй эсэх	Хөндлөнгийн аудитын чанар	Аудитын хороонд мэргэжлийн гишүүнтэй эсэх
СТ чанарын үнэлгээ	0.249 *	0.462 ***	0.159
Дотоод аудитын нэгжтэй эсэх		0.378 ***	0.577 ***
Хөндлөнгийн аудитын чанар			0.655 ***

Тайлбар: *, **, *** нь харгалзан 10, 5, 1 хувийн ач холбогдлын түвшинг илэрхийлнэ.

чанараас хамгийн өндөр хамааралтай буюу хамаарлын коэффициент 0.462 гарч судалгааны таамаглал 2 батлагдлаа. Харин дотоод аудитын нэгж болон санхүүгийн тайлангийн чанарын хооронд хамаарлын коэффициент 0.249 байгаа ба р утга нь 0.001-ээс их байгаа тул таамаглал 1 дэмжигдсэнгүй. Мөн аудитын хорооны мэргэшсэн байдал ба санхүүгийн тайлангийн чанарын хооронд хамаарлын коэффициент 0.159 байгаа ба р утга нь 0.001-ээс их байгаа тул таамаглал 3 дэмжигдсэнгүй. Мөн үл хамааран хувьсагчид болох хяналтын функцуудын хооронд хамаарал байгаа бөгөөд компани дотоод аудитын нэгж болон аудитын хороо нь мэргэжлийн гишүүнтэй байх тусам санхүүгийн тайлангийн үнэн зөв, шударга илэрхийлэлтэй байгаа эсэхийг аудитын салбарын "Их 4"-ийн аль нэгийг сонгон аудит ба баталгаажуулах үйлчилгээ авдаг болох нь судалгааны үр дүнгээр гарсан.

Дүгнэлт

Өмнө дурдсанчлан санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарын асуудал нь улс орнуудын хөрөнгийн зах зээлийн хөгжилд тулгамдаж буй нэн чухал асуудлуудын нэг хэвээр байна. Тиймээс ч сүүлийн

жилүүдэд санхүүгийн тайлагналын чанарт нөлөөх хүчин зүйл болон чанарыг хэмжих судалгаанууд ихээхэн хийгдэж байна. Манай улсын хувьд санхүүгийн тайлагналын чанарыг хэмжих хэд хэдэн судалгаанууд хийгдсэн байдаг ч ихэнх нь нягтлан бодогчийн санал асуулгын үр дүнгээр хэмжсэн байдаг байна. Тиймээс бид энэхүү судалгааны ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн чанар, түүнд компанийн хяналтын тогтолцоо хэрхэн нөлөө үзүүлдэг болохыг шалгахыг зорьсон. Санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих дөрвөн аргазүй байдаг боловч энэхүү судалгаанд бид санхүүгийн тайлангийн чанарыг 2009 онд Beest нарын боловсруулсан чанарын 5 хүчин зүйл, 21 асуулгыг ашиглаж санхүүгийн тайлангийн чанарын индексийг тооцоолсон. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ТӨП20 компанийн санхүүгийн тайлан, жилийн тайлангийн мэдээлэлд контент анализ аргыг ашиглан харьцуулалт хийж компани тус бүрийг 1-5 оноогоор үнэлсэн. Бидний судалгаагаар санхүүгийн тайлангийн чанарын индекс дунджаар 40 хувь гарсан ба энэ нь тийм ч сайн үзүүлэлт биш юм. Учир нь манай улсын хувьд 1996 оноос

эхлэн санхүүгийн тайлагналын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, санхүүгийн тайлангийн чанарыг СТОУС-д нийцүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Гэсэн хэдий ч санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэх нь дан ганц зохицуулагч байгууллага, стандарт тогтоогч болон мэргэжлийн байгууллагын үүрэг биш юм. Учир нь санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэхэд компанийн засаглал, хяналтын тогтолцоо болон хөндлөнгийн аудиторыг үүрэг роль чухал болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Мөн түүнчлэн бид санхүүгийн тайлагналын чанарт компанийн хяналтын тогтолцооны функцууд болон дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудиторын чанар болон аудитын хорооны мэргэшсэн байдал эерэг нөлөө үзүүлдэг эсэхийг шалгах 3 таамаглал дэвшүүлсэн ба үүнээс 1 таамаглал батлагдсан, 2 таамаглал дэмжигдээгүй. Үүнд:

- Санхүүгийн тайлагналын чанар нь 99 хувийн итгэх магадлалын түвшин хөндлөнгийн аудитын чанараас хамгийн өндөр хамааралтай буюу хамаарлын коэффициент 0.462 гарч судалгааны таамаглал 2 батлагдлаа.
- Дотоод аудитын нэгж болон санхүүгийн тайлангийн чанарын хооронд хамааралын коэффициент 0.249 байгаа ба р утга нь 0.001-ээс их байгаа тул таамаглал 1 дэмжигдсэнгүй.
- Аудитын хорооны мэргэшсэн байдал ба санхүүгийн тайлангийн чанарын хооронд хамааралын коэффициент 0.159 байгаа ба р утга нь 0.001-ээс их байгаа тул таамаглал 3 дэмжигдсэнгүй.

Компани дотоод аудитын нэгж болон

аудитын хороо нь мэргэжлийн гишүүнтэй байх тусам санхүүгийн тайлангийн үнэн зөв, шударга илэрхийлэлтэй байгаа эсэхийг аудитын салбарын “Их 4”-ийн аль нэгийг сонгон аудит ба баталгаажуулах үйлчилгээ авдаг болох нь судалгааны үр дүнгээр гарсан. Эцэст нь дүгнэхэд санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэхэд хөндлөнгийн аудиторын үүрэг маш чухал бөгөөд ялангуяа хөндлөнгийн аудитын чанарыг нэмэгдүүлснээр санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэх боломжтой, мөн аудитын хорооны мэргэшсэн байдал чухал гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн чанарт аудитын хороо, дотоод аудит, хөндлөнгийн аудитын чанар нөлөө үзүүлдэг эсэхийг хэмжихийг зорьсон ба бидний судалгаагаар санхүүгийн тайлагналын чанарыг нэмэгдүүлэхийн тулд компанийн засаглалыг сайжруулах, аудитын хорооны чадавхийг нэмэгдүүлэх, хорооны гишүүдийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн тайлагнал болон аудит, дотоод хяналттай холбоотой чиг үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна. Мөн хувьцаат компанийн санхүүгийн тайлагналын чанар болон аудитын чанарт зохицуулагч байгууллагаас тавих хяналт шалгалтыг сайжруулах шаардлага харагдаж байна. Тиймээс цаашид санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс тэр дундаа зохицуулагч байгууллагын үүрэг оролцоог судлах, мөн аудитын чанарт нөлөөлөх хүчин зүйлс болон аудитын чанарыг хэмжих судалгааг үргэлжлүүлэн хийх шаардлагатай гэж үзлээ.

Ашигласан материал

- Bandara, R. M. S. (2020). *Measuring Financial Reporting Quality: An Approach Based on Qualitative Characteristics*. Doctoral Dissertation, University of Canterbury.
- Beest, F., Braam, G., & Boelens, S. (2009). *Quality of Financial Reporting: Measuring Qualitative Characteristics*. NiCE Working Paper 09-108, Radboud University Nijmegen.
- Bing, J., Huang, C. X., Li, A., & Zhu, X. (2014). *Audit Quality Research Report*. Australian National Centre for Audit and Assurance Research.
- Cheung, E., Evans, E., & Wright, S. (2010). An Historical Review of Quality in Financial Reporting in Australia. *Pacific Accounting Review*, 22(2), 147-169.
- Clinch, G., Stokes, D., & Zhu, T. (2010). Audit Quality and Information Asymmetry between Traders. *Accounting and Finance*, 52(3), 743-765.
- DeZoort, F. (1997). An Investigation of Audit Committee's Oversight Responsibilities. *Abacus*, 33(2), 208-227.
- Herath, S. K., & Albarqi, N. (2017). Financial Reporting Quality: A Literature Review. *International Journal of Business Management and Commerce*, 2(2), 1-14.
- IASB. (2008). *Exposure Draft - An Improved Conceptual Framework for Financial Reporting*. London.
- IASB. (2018). *International Financial Reporting Standards*. IFRS Foundation.
- Mbobo, M. E., & Ekpo, N. (2016). Operationalising the Qualitative Characteristics of Financial Reporting. *International Journal of Finance and Accounting*, 5(4), 184-192.
- Nallareddy, S., & Ogneva, M. (2017). Predicting Restatements in Macroeconomic Indicators using Accounting Information. *The Accounting Review*, 92(2), 151-182.
- Ninjin, B. (2019). *Agency Relationship and Financial Disclosure Effect on Information Asymmetry: Evidence from Mongolia*. Doctoral Dissertation, University of Pecs.
- Onuorah, A. C. & Friday, I. O. (2016). Corporate Governance and Financial Reporting Quality in Selected Nigerian Company. *International Journal of Management Science and Business Administration*, 2(3), 7-16.
- Sami, M. (2009). The Role of Audit Committees in Corporate Governance and their Impact on the Quality of Financial Statements - Evidence from Egypt. *Journal of Faculty of Business for Scientific Researches*, 46(2), 1-42.
- Аюуш, Ц. (2009). *Компаний засаглал*. Улаанбаатар.
- Гантулга, Г. (2018). *Санхүүгийн тайлангийн мэдээллийг чанарыг хэмжих нь*. Улаанбаатар.
- Дэлхийн Банк. (2008). *НББ, Аудитын СДЖХӨҮТ*. Улаанбаатар.

Хавсралт 1. Компани тус бүрийн санхүүгийн тайлангийн чанарын индекс

№	Компанийн симбол	2018	2019	2020
1	GOV	84.21%**	46.32%	48.42%
2	MNP	47.37%	47.37%	47.37%
3	LEND	54.74%	60.00%	37.89%
4	AIC	64.21%	41.05%	53.68%
5	TUM	44.21%	35.79%	36.84%
6	MMX	41.05%	45.26%	3.16%
7	ADU	40.00%	48.42%	42.11%
8	AARD	47.37%	51.58%	51.58%
9	ADB	55.79%	54.74%	49.47%
10	ERDN	58.95%	58.95%	53.68%
11	APU	51.58%	55.79%	64.21%**
12	TTL	38.95%	38.95%	2.11%
13	BODI	0.00%*	0.00%*	45.26%
14	MNDL	44.21%	86.32%**	3.16%
15	SUU	36.84%	38.95%	3.16%
16	MFC	0.00%*	46.32%	45.26%
17	BDS	55.79%	57.89%	51.58%
18	NEH	40.00%	6.32%	0.00%*
19	INV	49.47%	49.47%	44.21%
20	UID	28.42%	24.21%	28.42%
	Ерөнхий дундаж	44.16%	44.68%	35.58%

Тайлбар: * - Хамгийн бага утга, ** - Хамгийн их утга